



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/145

Шивээговь сум

**Тамхи худалдан борлуулах тусгай
 зөвшөөрөл олгох тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4 дэх заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 86 дугаар тогтоол “Сумын нутаг дэвсгэрт тамхины худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Нараа” хүнсний мухлагт тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 2 жилийн хугацаатай олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийн хураамж болох 250000 /хоёр зуун тавин мянга/ төгрөгийг Орон нутгийн орлогод төвлөрүүлж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

3. “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” болон “Тамхины хяналтын тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийг мөрдөж ажиллахыг иргэн (Г.Наранчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

42121-573